



УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ 50 ТӨГРӨГ, 100 ТӨГРӨГНИЙ ДЭВСГЭРТИЙГ ХУУЛЬ ЁСНЫ ТӨЛБӨРИЙН ХЭРЭГСЭЛД ТООЦОХ, ГҮЙЛГЭЭНД ГАРГАХЫГ ЗӨВШӨӨРӨХ ТУХАЙ 1993 оны 7 дугаар сарын 9-ний өдөр Улаанбаатар хот Дугаар 54 Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь: 1."Мөнгөн тэмдэгтийн хэв загварыг батлах тухай" Улсын Бага Хурлын 1992 оны 5 дугаар сарын 19-ний өдрийн 32 дугаар тогтоолын дагуу хэвлэгдсэн "50 төгрөг", "100 төгрөг"-ийн дэвсгэртийг Монгол Улсын хууль ёсны төлбөрийн хэрэгсэлд тооцсугай. 2.Бэлэн мөнгөний гүйлгээний байдал, хэрэгцээг харгалзан Монгол Улсын Банкны хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасныг үндэслэн "50 төгрөг", "100 төгрөг"-ийн дэвсгэртийг гүйлгээнд гаргахыг Монголбанк (Д.Молломжамц)-д зөвшөөрсүгэй. 3.Энэ тогтоолыг 1993 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөхөөр тогтоосугай. ДАРГА Н.БАГАБАНДИ ТАМГЫН ГАЗРЫН ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА Н.РИНЧИНДОРЖ